



**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2021 оны 01 сарын 19 өдөр

Дугаар A/07

Улаанбаатар хот

**Журам шинэчлэн батлах
тухай**

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 71 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн, Амгалан дулааны станц ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны 2020 оны 01 тоот зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


1. Амгалан дулааны станц хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрийг 100 хувь төрийн өмчит бие даасан хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулсантай холбогдуулан “Хор саармагжуулах бүтээгдэхүүнийг хадгалах, олгох журам”-ыг нэгдүгээр, “Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцасны олголт, ашиглалтын журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаал батлагдан гарсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2016 оны А/28, 2017 оны А/128 дугаар тушаалыг тус тус хүчингүйд тооцсугай.

3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс /Б.Ган-Очир/-т даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ *Ш.Баянмөнх* Ш.БАЯНМӨНХ





Амгалан дулааны станц ТӨХК-ийн
Гүйцэтгэх захирлын 2021 оны 01 дүгээр сарын
19-ны өдрийн 1/07 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**ХОР СААРМАГЖУУЛАХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ
ХАДГАЛАХ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Амгалан дулааны станц ТӨХК-ийн хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа ажилтнуудад эрүүл ахуйн шаардлага, стандарт хангасан хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүн олгож ажилтны эрүүл мэндийг нөхөн сэргээх, хортой хүчин зүйлийн нөлөөллийг бууруулах, мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

1.2. Энэхүү журмаар Амгалан дулааны станц ТӨХК-ийн ажилтнуудад хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх, хадгалах, олгох, хяналт тавихад үүсэх харилцааг зохицуулна.

1.3. Энэхүү журам нь Монгол Улсын хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалын хэрэгжилтийг хангахад чиглэгдэнэ.

**Хоёр. Хор саармагжуулах бүтээгдэхүүнийг
хадгалах, олгох, хэрэглээг хянах, тооцоо хийх**

2.1. Хор саармагжуулах бүтээгдэхүүнийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар дүйцүүлэн гаргасан захирлын тушаалын дагуу “Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөл”-д ажилладаг ажилтнуудад олгоно.

2.2. Хор саармагжуулах бүтээгдэхүүнийг тухайн бүтээгдэхүүний шаардлага хангасан байранд эмх цэгцтэй хадгална.

- 2.3. Бүтээгдэхүүнийг олгохдоо доорхи нөхцлүүдийг бүрдүүлнэ. Үүнд:
- Бүтээгдэхүүнийг зөвхөн биетээр олгоно /мөнгөн хэлбэрээр олгохгүй/
 - Бүтээгдэхүүнийг тухайн ажилтныг хариуцсан инженер няраваас хүлээн авна.
 - Бүтээгдэхүүнийг ажлын байранд нь өдөрт нь хэрэглүүлнэ ./нөхөн олгохгүй/
 - Хэрэв шаардлагатай бол урьчилан олгож болно. /Амралт, баяр ёслолын өдрүүд/
 - Хор саармагжуулах бүтээгдэхүүн нь шингэн хэлбэрээр өдөрт 1 хүнд 0,25 граммаар олгоно.

2.4. Хариуцсан ажилтан хордлого тайлах бүтээгдэхүүнийг олгосон тухай баримтыг үнэн зөв хөтөлнө.

Гурав. Компанийн үүрэг

3.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.9 дэх заалт, Монгол Улсын эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 171 дугаар тушаал зэргийг үндэслэн хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүнийг гэрээт байгууллагаар тогтмол хангуулна.

3.2. Хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүн нь Монгол Улсын стандартын дагуу савлах, хадгалах, тээвэрлэх журмыг хангасан байна.

Дөрөв. Ажилтны үүрэг

4.1. Ажилтан хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүнийг зөвхөн ажлын байранд хэрэглэх ба үүнд анхан шатны удирдах ажилтан нар хяналт тавьж ажиллана.

4.2. Ажилтан хүлээн авсан бүтээгдэхүүнээ зориулалтын бус нөхцөлд хадгалсан, ажлын байрнаас бусад нөхцөлд хэрэглэснээс үүссэн хордлого, бусад хохирлыг бүтээгдэхүүн нийлүүлэгч болон ажил олгогч хүлээхгүй.

4.3. Ажил олгогчоос олгосон хор саармагжуулах бүтээгдэхүүнийг ажилтан ажлын байрнаас гадуур хэрэглэх, авч гарах, худалдах, өөр бүтээгдэхүүнээр солихыг хориглоно.


4.4. Хор саармагжуулах бүтээгдэхүүний чанар, олголттой холбоотой санал, хүсэлтээ ХАБЭА инженерт өгнө.

Тав. Бусад

5.1. Ажилтан хор саармагжуулах бүтээгдэхүүнийг ажлын байранд хэрэглэж байгаад хариуцсан цехийн дарга, хэсгийн инженер хяналт тавьж ажиллана.

5.2 Энэхүү журмын биелэлтэнд Хяналтын хэсэг хяналт тавьж ажиллана.

Гүйцэтгэх захирлын 2021 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 1107 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



НЭГ БҮРИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ, АЖЛЫН ХУВЦАСНЫ ОЛГОЛТ БА АШИГЛАЛТЫН ЖУРАМ

Нэг. Зорилго

1.1 Энэхүү журмын зорилго нь “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн нийт ажилтнуудын өвөл, зуны ажлын хувцас болон нэг бүрийн хамгаалах хэрэгсэлээр хангах, бүртгэх, хянах үйл ажиллагааны харилцааг зохицуулна.

1.2 “Амгалан дулааны станц” ТӨХК-нд ажиллаж буй нийт ажилтан, нэг бүрийн хамгаалах хэрэгсэлийг заавар болон зориулалтын дагуу “АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАСНЫ ДАРАА АЖЛАА ЭХЭЛБЕ!” уриан дор, тогтмол, зөв хэрэглэж хэвшүүлэх зорилготой.

Хоёр. Үйлчлэх хүрээ

2.1 Энэхүү журмыг “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн нийт ажилтан станцын үйлдвэрлэлийн газруудад байх үедээ дагаж мөрдөнө.

2.2 Энэхүү журмыг ашиглалтын инженер, шууд удирдлагууд ажилчиддаа танилцуулах үүрэг хүлээнэ.

Гурав. Тодорхойлолт, нэр томъёо

3.1 “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн нийт ажилтнуудын ажлын хувцас нь батлагдсан өнгө загвар, иж бүрдэл бүхий стандартын шаардлага хангасан байна.

3.2 “Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл” гэж үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах зориулалт бүхий стандартад нийцсэн доорхи хэрэгслүүдийг хэлнэ. Үүнд:

3.2.1 Хамгаалалтын болон гэрэл ойлгогч бүхий хувцас

3.2.2 Толгой хамгаалах хэрэгсэл

3.2.3 Нүд хамгаалах хэрэгсэл

3.2.4 Хөл хамгаалах хэрэгсэл

3.2.5 Гар хамгаалах хэрэгсэл

3.2.6 Сонсголын эрхтэн хамгаалах хэрэгсэл

3.2.7 Амьсгалын эрхтэн хамгаалах хэрэгсэл

3.2.8 Уналтаас хамгаалах аюулгүйн бүс багтана.

3.3 Осол: Үйлдвэрлэл түүнтэй адилтгах үйл ажиллагаанд оролцож байх явцдаа бие эрхтэн нь гэмтэх, эрүүл мэнд нь хохирох

3.4 Аюул: Механик, хими, хөлдөх, өндөр температурын буюу галын, био нэгдэл, цацрагийн зэрэг аюулын үйлчлэлээс бий болсон ослын бодит эх үүсвэр

3.5 Эрсдэл: Осол учруулах магадлалтай тохиолдлуудын нийлбэр буюу тухайн ослын зэрэглэл

3.6 Ажлын тусгай хувцас: Гадны нэг болон хэд хэдэн тааламжгүй нөлөөллөөс хамгаалах зориулалтаар хийсэн хувцас

3.7 Ажлын хувцасны иж бүрдэл нь доорх хэсгээс бүрдэнэ.

- Өвөл: Куртик, өмд, гутал
- Зун: Цамц, өмд, сорочик, гутал

3.8 Хамгаалах хэрэгсэл: Ажилтнуудыг цахилгааны үйлчлэл, өндрөөс унах, галд өртөх, дулаан ба механик үйлчлэлд нэрвэгдэхээс болон гэмтэхээс хамгаалахад зориулсан хүний аюулгүй байдлыг бүрэн хангаж чадах тусгаарлагч материалаар хийсэн хөдөлмөрийн багаж хэрэгслүүд

3.9 Үйлдвэрлэлийн газрууд :Үйлдвэрлэл үйлчилгээ явагдаж байгаа бүх газрууд болно

3.10 Үйлдвэрлэлийн бус газрууд: Захиргааны байр, хоолны өрөө, амралтын байр, ариун цэврийн өрөөнүүд болно.

Дөрөв. Ерөнхий шаардлага

4.1 Нэг бүрийн хамгаалах хэрэгслийг тухайн ажил үүргийг гүйцэтгэхэд зохицсон эсэхийг ажилтан болон шууд удирдлага доорхи шаардлагуудын дагуу магадлана. Үүнд:

- 4.1.1 Ажлын тусгай хувцасны материал, бүрдэл хэсгүүд нь тухайн ажилтанд саад болохгүй байх
- 4.1.2 Ажилтныг шаардагдах түвшинд хамгаалахаас гадна хүний биед тохиромжтой байх
- 4.1.3 Ажлын хувцасны хүний биед хүрэлцэх хэсгүүд нь аливаа цочроо, шархлаа үүсгэхгүй, ширүүн хурц ирмэггүй байх
- 4.1.4 Хувцасны загвар нь хөдөлмөрийн нөхцөл биеийн хөдөлгөөний онцлогт тохирсон байхаас гадна хувь хүнд тохируулан хэмжээг нь өөрчилж болохуйц, эсвэл хэмжээний өргөн сонголттой байх
- 4.1.5 Хөдөлгөөн болон гадаад орчны хүчин зүйлүүдийг тооцсон хэрэглээний хугацааг урьдаас тооцож баталгаажуулсан байх
- 4.1.6 Хувцасны хамгаалалтын түвшин өндөр, бөх бат хийгдсэн, хөнгөн, эдийн засгийн хувьд үр ашигтай байх
- 4.1.7 Ажлын тусгай хувцас нь боломжтой хэмжээгээр ус уур нэвтрүүлэхгүй байх, биед нөлөөлөх бусад хүчин зүйлийг бага болгох буюу байхгүй байлгах хэрэгтэй.
- 4.1.8 Хамгаалах хэрэгслүүд нь MNS 49312000, 53882004, 53892004, 56202006, 56212006, 5622 2006, 56232006, 56242006 стандартуудыг хангасан байх

- 4.1.9 Хамгаалах хэрэгсэл бүр баталсан норматив техникийн баримт бичигтэй, бүрэн хамгаалах чадвартай, гоо зүйн болон эргономикийн шаардлага хангасан байх
- 4.1.10 Тусгай хамгаалах хэрэгсэл нь ашиглалт, эрүүл ахуй, физиологи, хамгаалалтын үнэлгээг үнэлсэн үзүүлэлт, ашиглалтын заавартай байх
- 4.2 Ажилтан өөрийн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцасны бүрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэй.
- 4.3 Ажлын талбарт ямар нэгэн ажил гүйцэтгэхдээ аюулгүй ажиллагааны дүрмээр заавал биелүүлэх аюулгүйн тэмдэг тэмдэглэгээгээр заагдсан нэг бүрийн хамгаалах хэрэгслийг заавал хэрэглэнэ.
- 4.4 Ээлжийн амралт, хуваарьт амралт, ажлын бус цагаар нэг бүрийн хамгаалах хэрэгсэл ажлын хувцас хэрэглэхийг хориглоно.
- 4.5 Ажилтан амралтаа дуусган ирэх үед нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцсыг ахлагч нь дахин шалгана.
- 4.6 Зочид, ажил шалгах, танилцах зорилгоор талбай дээр ажиллах хүмүүсийг дараах хамгаалалтын хэрэгслээр түр хангана:
- 4.6.1 Гэрэл ойлгогч тууз бүхий хантааз
 - 4.6.2 Дуулга /цэнхэр/
 - 4.6.3 Хамгаалалтын шил

Тав. Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцасны ашиглалтын хугацаа

- 5.1 Ажлын хувцасны өнгө загвар иж бүрдлийг ХАБЭА-н зөвлөл хариуцан батлуулна.
- 5.2 Ажилтнуудын хувцасыг батлагдсан нормын дагуу олгох ба зуны хувцасыг жилийн 3 сард, өвлийн хувцасыг жилийн 10 сард олгох ажлыг Хангамжийн хэлтэс хариуцна. Мөн ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг хугацаанд нь олгоогүй бол хожимдуулсан хугацааг элэгдлийн хугацаанд тооцож байна.
- 5.3 Хөдөлмөрийн хамгаалалтын хувцасны ерөнхий шаардлага- MNS ISO 13688 :2000, MNS ISO 136885 1998 гэсэн стандартуудыг мөрдөнө. Энэ стандартаар ажлын тусгай хувцасны эргономик, ашиглалтын хугацаа, хэмжээ, марк, угаалга цэвэрлэгээнд тавих ерөнхий шаардлагыг тогтоосон.
- 5.4 Санхүү эдийн засгийн хэлтэс нь шаардлага хангахгүй болсон ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгсэлийг акт үйлдэн устгана.
- 5.5 Нэг бүрийн хамгаалах хэрэгслийг ажлын нөхцөл болон элэгдлээр нь тооцон нэмж олгохын тулд “Шаардах хуудас”-ыг санхүүгээр шалгуулан бүртгүүлээд, няраваар олгуулна.
- 5.6 Ажилтан нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцасныхаа ашиглалтын хугацаа дууссан, цэвэрлэх боломжгүй болох, аюулгүйн шаардлага хангахгүй болох зэрэг шалтгааны улмаас солих шаардлага гарсан бол шууд удирдлагадаа хүсэлт тавина.
- 5.7 Ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгсэлийн нөөцийг тухайн жилийн нийт ажилтнуудын 20 хүртэлх хувиар тооцно.

Зургаа. Хяналт, хариуцлага

6.1 Журмын хэрэгжилтэд хяналт тавих, мөрдүүлж ажиллах үүргийг “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн Хяналтын хэлтэс хариуцах бөгөөд журам зөрчсөн ажилтан болон харьяалах удирдлагад шаардлага тавьж зөрчлийг арилгах эрхтэй.

6.2 Энэхүү журмыг зөрчсөн ажилтны санаатай болон болгоомжгүй, хайхрамжгүй байдал, гэм буруутай үйлдлийн улмаас нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцсыг алга болгох, гэмтээх, хэрэглэх боломжгүй болсон тохиолдолд холбогдох журмын дагуу хариуцлага ногдуулж, учирсан хохирлыг барагдуулна.

6.3 Ажилтан ажлаас халагдах, өөр ажилд шилжсэн тохиолдолд ажилласан сараар хувцасны элэгдэл хорогдлыг тооцож суутгахыг Санхүү эдийн засгийн хэлтэс хариуцан авна.

6.4 Шууд удирдлага нь ажилтны ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгсэлийн ашиглалтанд хяналт тавина.

6.5 Хяналтын хэлтэс нь ажлын хувцас хэрэглэлийг ажлын байрнаас өөр газарт хэрэглэсэн, сахилгын зөрчил гаргасан тохиолдолд “Зөрчилд тооцох, зөрчлийн талон ашиглах хэрэгжүүлэх тухай журам”-ын дагуу арга хэмжээ авч ажиллана.

НЭГ БҮРИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЛИЙГ АШИГЛАХ ЗААВАР

Нэг. Толгой хамгаалах хэрэгсэл

1.1 Толгой хамгаалах хэрэгсэл /каска/-ыг ажлын талбарт ажиллаж байгаа нөхцөлд болон толгой дээрээс гадны биет унах эрсдэл бүхий газруудад байнга өмсөнө.

1.2 Удирдлага болон ажилчин зочидын толгой хамгаалах хэрэгсэлийн өнгийг доорхи байдлаар ялгана.

1.2.1 Удирдлага, ИТА – Цагаан

1.2.2 Ажилтан-Улбар шар

1.3 Албан өрөө, хоолны газар болон тээврийн хэрэгсэл дотор толгойн хамгаалалт буюу каска өмсөх шаардлагагүй.

1.4 Бүх ажилчид өөрсдийн хамгаалалтын каскаа шалгах, цэвэрлэх, засварлах үүрэгтэй.

Хоёр. Нүд хамгаалах хэрэгсэл

2.1 Станцын бүх газруудад хамгаалалтын нүдний шил зүүнэ. Жич: үйлдвэрлэлийн бус газар тусгай ажил үүрэг гүйцэтгэх шаардлага гарвал ажилчид аюул ослоос урьдчилан сэргийлэх үүднээс нүдний шилийг заавал зүүх үүрэгтэй.

2.2 Тасдах төхөөрөмжин дээр ажиллагсад зориулалтын нүдний шил зүүсэн байна.

2.3 Гагнуур хийж буй ажиллагсад гагнуурын зориулалтын нүд, нүүрний хамгаалалт зүүсэн байна.

2.4 Ямар нэгэн зорогч (ширээн дээр суурилуулсан буюу цахилгаан гар зорогч) ажиллуулдаг эсвэл ийш тийш цацагдаж болох идэмхий материалтай харьцдаг ажиллагсад нүүрний хамгаалалтын хэрэгслийг заавал зүүнэ.

2.5 Ажилтануудад нүдэндээ гэмтэл авахаас урьдчилан сэргийлж нэмэлт хамгаалалт бүхий чанарын шаардлага хангасан нүүрний хаалт, эсхүл хамгаалалтын зориулалтын шил зүүх үүрэгтэй.

2.6 Байгалийн гамшигт үзэгдэл, салхи шуурга, нарнаас хамгаалсан шил зүүнэ.

2.7 Контакт линзийг үйлдвэрлэлийн газруудад зүүхгүй.

2.8 ХХХ эзэмшигч нь хариуцсан аливаа хэрэгслээ хэрхэн арчлах, хадгалах тухай зааврын дагуу, заасан хугацаанд эдлэх үүрэгтэй

Гурав. Хөл хамгаалах хэрэгсэл

3.1 Түр гэрээгээр ажиллаж ажилчдыг шаардлагатай гэж үзвэл хамгаалах хэрэгслээр хангана.

3.2 Хамгаалалтын ажлын гутлаа сайтар үдсэн байх ёстой.

3.3 Ажилтнууд хальтрах аюулаас болгоомжлохын тулд, хамгаалалтын гутлын ул элэгдсэн эсэхийг өөрсдөө шалгаж байх шаардлагатай.

3.4 Станцад ажиллаж байгаа бүх ажилтнууд шагайн бүтэн хамгаалалттай гутал өмсөнө.

3.5 Төмөр хошуун хамгаалалт бүхий гутлыг үйлдвэрлэлийн бус газар өмсөх шаардлагагүй боловч, энгийн гутлыг үйлдвэрийн талбай дотор өмсөхийг хориглоно.

Дөрөв. Гар хамгаалах хэрэгсэл

4.1 Бүх ажилтнууд гар гэмтэх магадлалтай ажил хийж гүйцэтгэхдээ тухайн ажилд тохирсон гарын хамгаалалт буюу бээлийг заавал өмсөх хэрэгтэй.

4.2 Гагнуур хийх, тасдагч ажиллуулж байгаа тохиолдолд зориулалтын бээлий өмсөнө.

4.3 Химийн бодистой харьцахад зориулалтын резинэн бээлий өмсөнө.

Тав. Хамгаалалтын болон гэрэл ойлгогч бүхий хувцас

5.1 Хортой болон идэмхий бодисын аюул бүхий орчинд ажиллах тохиолдолд ус нэвтэрдэггүй хамгаалалтын хувцсыг байнга өмсөнө.

5.2 Ажилтнууд өөрсдийнхөө хувцсыг таарч байгаа эсэхийг магадлана. Хэт томдсон хувцсыг үйлдвэрлэлийн газруудад өмсөхийг хориглоно.

5.3 Ашиглаж байгаа тоног төхөөрөмжтэй орооцолдох аюултай үед урагдсан хувцсыг сольж, унжсан зүйлийг авч хаяна.

5.4 Майк, богино өмд, ханцуйгүй цамцыг ажлын талбарт өмсөхийг хориглоно.

Зургаа. Сонсголын эрхтэн хамгаалах хэрэгсэл

6.1 Дуу чимээ ихтэй газар болон дуу чимээ их гэсэн тэмдэг бүхий газруудад сонсгол хамгаалах хэрэгсэл хэрэглэнэ.

6.2 Ажилтнууд үйлдвэрлэлийн газар байгаа тохиолдолд чихэвчний радио, хуурцаг тоглуулагч, зөөврийн хөгжим, кино тоглуулагч зэрэг зүйлсийг хэрэглэхгүй ба зөвхөн ажлын зориулалтаар гар утсыг ашиглана.

Долоо. Амьсгалын эрхтэн хамгаалах хэрэгсэл

7.1 Үйлдвэрлэлийн тоос, химийн бодис, утаа, угаар болон агаарын найрлаган дахь хорт хийн бүтээгдэхүүнээс хамгаалах зорилгоор амьсгал хамгаалах хэрэгсэл болох нэг удаагийн амны хаалт, хошуувчтай амьсгалын баг, тусгай хий соруулсан амьсгалах хэрэгсэл, амьсгалын аппарат зэргийг хэрэглэнэ.

7.2 Агаарт тархсан тоосонцор, утаа тортог, хорт утаа, хий, уур манан ба ууршилтай орчинд ажиллагсад тухайн нөхцөлд тохирсон зориулалтын амьсгалын эрхтнийг хамгаалах хэрэгслийг заавал хэрэглэнэ.

7.3 Ялангуяа сорьц дээжинд шинжилгээ хийх лаборатори, сорьцонд галын шинжилгээ хийх бол ажиллагсад нүүрийг бүрэн битүүмжлэн хаасан зориулалтын маск зүүх ёстой ба зориулалтын маск зүүгээгүй ажиллагсдыг дээрх газруудад ажиллахыг хатуу хориглоно.

7.4 Амьсгалын замыг хамгаалах хэрэгслийг хэрэглэж буй ажилтан нь олон удаагийн хэрэглэх хэрэгслийг өөрсдөө цэвэрлэж арчилж, цэвэр тоосгүй орчинд хадгалах үүрэгтэй.

7.5 Амьсгал хамгаалах хэрэгслийн шүүлтүүрийг тухайн агаарын бохирдолд тохируулан хэрэглэнэ.

Найм. Уналтаас хамгаалах бүс

8.1 “Амгалан дулааны станц” ТӨХК нь өөрсдийн ажилтанг уналтаас хамгаалах хэрэгслээр хангаж ажиллана.

8.2 Уналтаас хамгаалах хэрэгслийг доорх нөхцөлд ажиллаж буй ажилтанууд заавал хэрэглэх шаардлагатай:

8.2.1 Нэг метрээс дээш байнгын суурилуулсан өндөрт ажиллагсад, 3 метрээс дээш түр суурилуулсан өндөрт ажиллагсад хашлага хаалт, бариул байхгүй нөхцөлд ажиллах

8.2.2 Ажилтанууд битүү сав, ёмкость, бункер, амьсгаа боогдож бахардаж болзошгүй орчинд ажиллах

8.2.3 Ажилтанууд ямар нэгэн химийн бодис, янз бүрийн материалтай сав болон ажиллаж байгаа машин техник рүү унаж болзошгүй нөхцөлд ажиллах

8.3 Ажилтанууд унахаас хамгаалах хэрэгслийг хэрэглэхийн өмнө өөрсдөө биечлэн хамгаалалтын хэрэгсэлд ямарваа нэг эвдрэл гэмтэл байгаа эсэхийг сайтар шалгах үүрэгтэй.

8.4 Эвдрэл гэмтэлтэй хамгаалалтын хэрэгсэл хэрэглэхийг хатуу хориглоно.

8.5 Унахаас хамгаалах бүх хэрэгслийг хэрэглээгүй үедээ зориулалтын хадгалдаг газар нь буцааж өгч зөв хурааж хадгална.